



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

Гадаад сурталчилгааны материал хэвлүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/60 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэл Улаанбаатар хотыг гадаад улсад сурталчлах, жуулчдыг хэрэгцээт мэдээллээр хангах, олон улсын үзэсгэлэн, арга хэмжээний үеэр тараах зорилгоор сурталчилгааны материал хэвлүүлэх ажлыг зохион байгуулсугай.

2. Арга хэмжээ зохион байгуулахад шаардагдах төсөв 90,900,000 (ерэн сая есөн зуун мянга) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (Д.Уянга)-д зөвшөөрсүгэй.

3. Сурталчилгааны материал хэвлүүлж, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (С.Туул)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2024 оны 01 сарын 18-ны өдрийн
А01 дугаар тушаалын хавсралт

ГАДААД СУРТАЛЧИЛГААНЫ АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛАХАД
ШААРДАГДАХ ТӨСВИЙН ЗАРДЛЫН ЗАДАРГАА

2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Улаанбаатар хотын сурталчилгааны сэтгүүл хэвлүүлэх (Англи хэлээр)	3000 ширхэг	6000	18,000,000
2	Улаанбаатар хотын сурталчилгааны сэтгүүл хэвлүүлэх (Хятад хэлээр)	3000 ширхэг	6000	18,000,000
3	Улаанбаатар хотын сурталчилгааны сэтгүүл хэвлүүлэх (Солонгос хэлээр)	2000 ширхэг	6000	12,000,000
4	Улаанбаатар хотын сурталчилгааны сэтгүүл хэвлүүлэх (Япон хэлээр)	1000 ширхэг	6000	6,000,000
5	Улаанбаатар хотын сурталчилгааны сэтгүүл хэвлүүлэх (Герман хэлээр)	1000 ширхэг	6000	6,000,000
6	Улаанбаатар хотын сурталчилгааны сэтгүүл хэвлүүлэх (турк хэлээр)	1000 ширхэг	6000	6,000,000
7	Улаанбаатар хотын хөтөч ном хэвлүүлэх (Англи хэлээр)	2000 ширхэг	6700	13,400,000
8	Жуулчдад зориулсан Улаанбаатар хотын газрын зураг хэвлүүлэх	5000 ширхэг	1700	8,500,000
9	Сэтгүүлийн эх бэлтгэл, дизайны хийх	Багц	3 000 000	3,000,000
НИЙТ				90,900,000